



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Аудитор М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Улаанбаатар хот, Төрийн захирлын газар, 83199
Утас: 7048-14-11, Факс: 7048-14-12
Хүргэлэх газар: govinfo@aud.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТОНХИЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б БАЯНЖАРГАЛ
ТАНАА**

2023.02.24

63

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар тэтгэвэрт гарсан ажилчинд тэтгэмж илүү олгосон, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд дуусгалын тооцоо хийгээгүй, батлагдсан орон тооны дагуу ажиллаагүй, гэрээний хугацаа дууссан байхад малыг дараагийн айл өрхөд шилжүүлээгүй, нийгмийн даатгалд цалин хөлсийг илүү, дутуу тайлагнасан, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, шилэн дансанд зарим мэдээллийг мэдээлээгүй зэрэг 132.1 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг, засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэхээр заасан боловч Төрийн хэмнэлтийн хуулиар дээрх арга хэмжээний зардлыг хориглосон байна.

Тайлант онд 1.495.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

0702000087

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 85.8 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	151,895.34	165,970.54
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	760,201.70	2,131,868.54
	Нийт хөрөнгийн дүн	912,097.04	2,297,839.08
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	912,097.04	2,297,839.08
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	912,097.04	2,297,839.08
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	459,511.38	1,997,472.30
	Үйл ажиллагааны зардлын дүн	516,465.79	611,730.26
	Үйл ажиллагааны үр дүн	-56,954.41	1,385,742.04
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-56,954.41	1,385,742.04
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	969,051.45	912,097.04
	Тайлант оны үр дүн	-56,954.41	1,385,742.04
	Эцсийн үлдэгдэл	912,097.04	2,297,839.08
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	393,779.90	502,058.66
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	362,160.12	469,968.26
	Үйл ажиллагааны ЦМГ	31,619.78	32,090.40
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-31,619.78	-32,090.40
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	365,917.84	452,844.52
	Урсгал зардал	334,298.06	420,754.12
	Хөрөнгийн зардал	31,619.78	32,090.40
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	365,917.84	452,844.52
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	365,797.84	452,844.52
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	120.00	
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 47.3 сая төгрөгийн алдаа¹ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 0.4 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- ✓ Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг 44.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Хууль тогтоомжтой холбоотой:

- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 2.6 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 132.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 6 заалт албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 3 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Нийгмийн даатгалын тайланд улирлын шинжтэй ажилтныг үндсэн ажилтнаар тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэлд 0.3 сая төгрөг, 2.8 сая төгрөгийн цалин илүү тайлагнаж 0.3 сая төгрөг, нийт 0.6 сая төгрөгийн НДШ илүү төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 2-т "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудад амралтын дуусгавар тооцоо хийгээгүйн улмаас 0.1 сая төгрөгийн амралтын мөнгө илүү, 0.1 сая төгрөгийн амралтын мөнгө дутуу олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна",¹¹⁰

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Гар утасны төлбөрт 0.3 сая төгрөгийг төсвөөс төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно 12.1.1-т "гар утасны зардал" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчинд төрийн албанд ажилласан жилийг буруу тогтоож 1.4 сая төгрөгийн тэтгэмжийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2-т "Энэ журмын 1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон төрийн албан хаагчид 2.1-д зааснаар тогтоосон үндсэн цалингийн дунджийг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоотой тэнцэх сарын тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэгч сурагчдын дунд зохион байгуулсан уралдааны шагналд 1.2 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 5.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг зөрчсөн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Аймгийн Засаг даргын баталсан бүтэц орон тоогоор нярав үйлчлэгч 1 орон тоогоор байхад тус бүр нэг орон тоогоор ажиллуулж 6.4 сая төгрөгийн цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн А/630 дугаар захирамжийг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нийгмийн даатгалын хэлтэст 2.8 сая төгрөгийн цалин илүү тайлагнасан, 0.3 сая төгрөгийн цалинг нийгмийн даатгалд тайлагнаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1-т "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 1-т "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 2-т "Шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх", Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах;" заалтыг

зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс сайн малчны шагнал арга хэмжээнд 5.9 сая төгрөг, тэмцээнд оролцох зардалд 0.6 сая төгрөг, авто үзлэгийн үйл ажиллагаанд 0.5 сая төгрөг тус тус зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 5.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 5.4.-т " бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашигладаггүй, талбайн хэмжээгээр халаалтын төлбөр хийдэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Аймгийн аюулгүйн нөөцийн 2500 боодол өвс тээвэрлэх ажлыг Сэлэнгэ аймгаас Тонхил сумын төвд хүргэж өгөхөөр гэрээ байгуулж тээврийн хөлсөнд 17.5 сая төгрөгийг олгосон боловч одоогийн байдлаар аймгийн төвд Хүнс хөдөө аж ахуйн газарт өвсийг буулгасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх"; 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах." Хоорондын байгуулсан ачаа тээврийн 2022 оны 10 дугаар сарын 05-ний өдрийн 01 дугаартай гэрээ 1.2 дахь заалт " Тээвэрлэгч нь 2022 оны 10 дугаар сарын 10-ний дөрөөс 25-ны өдрийн хооронд 2500 боодол өвсийг TRAILER8 GOLD маркын 5469 УБС, 25-42 УАР улсын дугаар бүхий хувийн унаагаар тээвэрлэн Говь-Алтай аймгийн Тонхил сумд хүргэнэ" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Гэрээний хугацаа дууссан байхад 110.0 сая төгрөгийн 995 толгой малыг дараагийн айл өрхөд шилжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", Тонхил сумын адууны чанарыг сайжруулах чиглэлээр ирсэн азарган үрээ авсан малчидтай хийсэн түрээсийн гэрээ, Тонхил сумын сарлаг үхрийн чанарыг сайжруулах ашиг

шимийг нэмэгдүүлэх түрээсийн гэрээ" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Өмнөх жилийн зөрчлийг давтан гаргасан, Төрийн аудитын байгууллагаас өгсөн 2022 оны 03/45, 08/45, 126/202 дугаартай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж


- ✓ Байгууллагын авто тээврийн хэрэгсэл нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн
- ✓ Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш 35 орлого, зарлагын гүйлгээнээс 7 мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмадын хорооны урамшуулалд 0.6 сая төгрөг, төрийн албан хаагчдын дархлааг дэмжих арга хэмжээнд 0.8 сая төгрөг, тээврийн хөлсөнд 0.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын Засаг даргын тамгын газар	7	47.31	5	36.10	2	11.21	7	47.31				
Дүн	7	47.31	5	36.10	2	11.21	7	47.31				



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Хууль, тушаалтны тоо
Тонхил сумын Засаг даргын тамгын газар	12	132.13	5	3.84	5	126.64	1	1.66	1	1
Дүн	12	132.13	5	3.84	5	126.64	1	1.66	1	1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны мэдээллийг дутуу мэдээллэсэн	1	-							1	
Дүн	1	0	0	0	0	0	0	0	1	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Автотээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй	1								1	
Дулааны тоолуур ашиглаагүй	1	-				1				
Дүн	2	0	0	0	1	0	1	0		0
Нийт дүн	3	-	-	-	1	-	2	-		-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		